



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 65

Мандалговь


Хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Худалдан авах ажиллагааны албанд хавсралтын дагуу өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 2,119,500 /хоёр сая нэг зуун арван есөн мянга таван зуу/ төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.
2. Шинээр бэлтгэсэн эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авахыг Худалдан авах ажиллагааны албаны дарга Ё.Мөнхбатад даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУДЖАВ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 11 сарын 16 өдрийн 65 дугаар тогтоолын хавсралт

Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Архивын шүүгээ	3	280,000	840,000
2	Ус шүүгч	1	402,000	402,000
3	Каноны автомат цаас татагч	1	877,500	877,500
Нийт дүн				2,119,500